



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТААР 2020-2021 ОНД ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ,
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГ ЗӨРЧИЖ ТАЙЛАГНАСАН 1,415,154.2
АМ.ДОЛЛАРЫН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫГ ХАСАЖ
БАТАЛГААЖУУЛЛАА

АУДИТЫН СЭДЭВ: ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ
ГЭРЭЭГЭЭР ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ,
ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО,
ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ АУДИТЫН ТАЙЛАН
АУДИТЫН КОД: СНАГ-2023/10-НА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

МУЕА-ын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын
газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням

Утас: 263755 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитын менежер Д.Отгонбаяр

Утас: 261729 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Жаргалсайхан

Утас: 261729 Цахим хаяг: jargalsaikhand@audit.gov.mn

Аудитор Ц.Цэрэннамжил

Утас: 261729 Цахим хаяг: tserennamjilts@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт”-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод, Монгол Улсын Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлэхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд (Ж.Ганбаатар), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Л.Баярмандал) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-д даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, танилцуулга хийхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Санхүү-нийцлийн аудитын газар (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НАРАНЧИМЭГ

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Санхүү- Нийцлийн аудитын газар:

МУЕА-ын орлогчийн
албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Ц.Наранчимээ

Аудитын нэгдсэн
удирдлага,
зохицуулалтын газрын
захирал, тэргүүлэх
аудитор

Я.Самбууням

Аудитын менежер
Д.Отгонбаяр

Ахлах аудитор
Д.Жаргалсайхан
Аудитор
Ц.Цэрэннамжил

2023 оны 12 дугаар сар

Тайланг ҮАГ-ын вэб
сайтаас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
261749, 260949
дугаарын утас, факсаар
харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын
газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3
Засгийн газрын
IY байр
Улаанбаатар хот
15160
Монгол Улс

Монгол Улсын Ерөнхий аудиторов тушаал	1
Агуулга	2
Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
Аудит хийх үндэслэл	4
Аудитын зорилт	4
Аудитын хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй	4
Үндсэн мэдээлэл	4-6
Бүлэг 1. Гэрээлэгчдийн холбогдох хууль тогтоомж, БХГ-д нийцээгүй 1,415,154.17 ам.долларын ӨНЗ-ыг аудитаар хасаж баталгаажууллаа.	7-12
1.1. Гэрээлэгч хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын хэмжээг санхүүгийн болон ӨНЗ-ын тайландаа үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна.	7-10
1.2. Гэрээлэгч нь БХГ болон холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	10-12
Бүлэг 2. Холбогдох төрийн байгууллагууд гэрээлэгчийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, БХГ-ний дагуу хяналт тавих үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй байна.	13-18
2.1. АМГТГ нь холбогдох хууль тогтоомж, БХГ-д заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.	13-15
2.2. Өмнөх аудит буюу 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн ӨНЗ-ыг баталгаажуулах аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	15-18
Дүгнэлт	19
Зөвлөмж	20-21
Хавсралт 1	22-29
Аудитад хамрагдагч болон холбогдох байгууллагын санал болон саналд өгөх тайлбар	30-39
Акт	40-42
Албан шаардлага	43-44

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс /хуучин нэрээр/
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ГТГ	Газрын тосны газар
ГТБТЖ	Газрын тосны бүртгэл, тооцооны журам
МАК	Монголын алт компани
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭТТ	Эрдэнэс таван толгой

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	2021 оны байдлаар хайгуулын үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулсан гэрээлэгчдийн мэдээлэл.
Хүснэгт 2	Гэрээлэгчдийн хайгуулын ажлын ӨНЗ-ыг баталгаажуулсан дүн.
Хүснэгт 3	Гэрээлэгчдийн гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн гүйлгээний дүн.
Хүснэгт 4	Хууль болон БХГ-д заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсийг 2023 оны жилийн эцсийн байдлаар төлөөгүй гэрээлэгчид
Хүснэгт 5	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар
Хүснэгт 6	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн талаар

Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3-т тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан аудитын жилийн төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт БХГ-ээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн 2020, 2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын хэмжээг Монгол Улсын хууль тогтоомж болон БХГ-ний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэхийг хянан баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэлээ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитаар Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу АМГТГ-аас ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийн хүрээнд 2021 онд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан Монголын алт /МАК/ ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Петровис ресурс ХХК, Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК-уудын 8 талбай болон 2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан Монголын алт /МАК/ ХХК, Петроматад ХХК, Макс Ойл ХХК-ийн 3 талбай буюу нийт 11 талбайд батлагдсан төлөвлөгөө, төсөв ӨНЗ-ын тайлан, холбогдох бусад баримт материал, үйл ажиллагааг хамруулсан.

Мөн УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ зэрэг төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааг хамруулан, БХГ-д оролцогч талуудын чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шаардлагатай баримт материалыг түүвэрлэн шалгав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4001, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” болон холбогдох заавар, аргачлалыг баримтлан гүйцэтгэсэн.

Гэрээлэгчийн хайгуулын талбайн 2020, 2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөж, хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, хайгуулын ажлын хөрөнгө оруулалт ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэхийг санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал, ерөнхий дэвтэр болон анхан шатны баримттай нь тулган баталгаажуулах горимыг хэрэгжүүлсэн.

Мөн холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тайлбар авах, газар дээр нь бодит гүйцэтгэлтэй тулган шалгах, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг АМГТГ хянаж, хүлээн авсан баримт материалыг нягтлах зэргээр нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл

Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 1991 оны Газрын тосны тухай хууль, “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар зохицуулж ирсэн бөгөөд 2014 оноос Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж байна.

Мөн 2020 онд тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын хэмжээ, санхүүгийн тайланг АМГТГ-аас хянан шалгаж, гаргасан тайлан дүгнэлтийг төрийн аудитын байгууллагад хүргүүлснээр аудит хийж, баталгаажуулах зохицуулалт тусгагдсан.

Тухайн зохицуулалтын хүрээнд АМГТГ-ын даргын 2022 оны А/120 дугаар тушаалаар 2020, 2021 онд уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-ӨНЗ-ыг хянан шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг томилон ажиллуулсан байна.

Тус Ажлын хэсгийн гүйцэтгэсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийг АМГТГ-аас 2023 оны 1/1541, 1/2184, 3/3192 дугаар албан бичгээр тус тус УАГ-т ирүүлсний дагуу холбогдох анхан шатны баримт материал, гэрээлэгчдийн гаргасан тайлан, мэдээнд тулгуурлан аудит хийсэн.

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 33 талбай ялгасан байгаагаас 2021 оны байдлаар Засгийн газрын шийдвэрийн дагуу АМГТГ-аас 21 гэрээлэгчийн 24 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах БХГ-г байгуулсныг дараах хүснэгтээр задлан харууллаа.

Хүснэгт 1. 2021 оны байдлаар хайгуулын үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулсан гэрээлэгчдийн мэдээлэл.

Гэрээлэгчийн		Талбайн		БХГ байгуулсан огноо	Хайгуулын үйл ажиллагаа явуулж, ӨНЗ-ын тайлан гаргасан	Хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан, үндэслэл					
№	Нэр	№	Нэр			Түр зогсолт авсан	Төлөвлөгөө, төсөл ирүүлэх мэдэгдэлтэй	Ашиглалтад шилжсэн	Шүүхийн маргаантай	Орон нутгийн эсэргүүцэлтэй	Цуцлах нөхцөл бүрдсэн, талбай буцаасан, гэрээний хугацаа дуусгавар болсон
1	Шунхлай Энержи ХХК	1	Сулинхээр XXXIII	10/7/2010				1			
2	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	2	Увс I	04/15/2015					1		
3	Монголиа Велпэк Индарстриал ХХК	3	Хэрлэн толгой ХХVIII	04/20/2015						1	
4	Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК	4	Номгон IX	2/29/2016						1	
5	Монголиа Шин Ий ХХК	5	Дарьганга XXIV	4/19/2016						1	
6	Түмэн ойл ХХК	6	Баянтүмэн XVII	6/18/2016		1					
7	Смарт ойл инвестмент ХХК	7	Эргэл XII	8/24/2016		1					
8	Реново -Илч ХХК	8	Хар-Ус II	1/5/2017						1	
9	Монголын-Алт ХХК	9	Төхөм-Х урд	6/16/2017		1					
10	Вульф Петролеум ХХК	10	Сүхбаатар ХХVII	6/16/2017			1				
11	Макс ойл ХХК	11	Арбулаг XXIX	8/31/2017			1				
12	Эн Пи Ай ХХК	12	Хөхнуур ХХVIII	9/21/2017						1	
13	Капкорп Монголиа ХХК	13	Онги V	6/5/2018		1					
		14	БогдV	6/5/2018						1	

14	Петроматад ХХК	15	Матад ХХ	6/8/2018				1			
15	Жи Өү Эй ¹ ХХК	16	Номгон IX	8/22/2018	1						
16	Шейман ХХК	17	Налга XVI	8/27/2018						1	
17	Зон хэн юу тиан ХХК	18	Галба XI	11/5/2019		1					
18	Тахь ресурс ХХК	19	T1	2/12/2020	1						
		20	Богд IV	2/12/2020	1						
		21	Онги V	2/12/2020	1						
19	Метан газ ресурс ХХК	22	Тавантолгой XXXIII	4/22/2020	1						
20	Чайна Голденсий петролеум эксплорэйшн корпорэйшн компани	23	Тариач XV	10/1/2020			1				
21	Тэлмэн ресурс ХХК	24	Гурвантэс XXXV	7/7/2021	1						
ДҮН					6	5	3	1	1	2	6

Эх сурвалж: АМГТГ-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/1541 дүгээр албан бичиг

Дээрх хүснэгтэд харуулснаар 2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан 4 гэрээлэгчийн 6 талбайгаас гадна Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэлх хугацааг болон Монголын-Алт ХХК-ийн Төхөм-Х урд талбайг оруулж нийт 6 гэрээлэгчийн 8 талбайг, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан хэдий ч ӨНЗ-ыг нь баталгаажуулаагүй үлдсэн Монголын алт /МАК/ ХХК, Петроматад ХХК, Макс Ойл ХХК-уудыг аудитад тус тус хамруулсан.

¹ Жи Өү Эйч ХХК нь Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т "уламжлалт бус газрын тос" гэж байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хийтэй занар, нүүрсний давхаргын метан хийг" гэж заасны дагуу уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулдаг.

БҮЛЭГ 1. ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БХГ-Д НИЙЦЭЭГҮЙ 1,415,154.17 АМ.ДОЛЛАРЫН ӨНЗ-ЫГ АУДИТААР ХАСАЖ БАТАЛГААЖУУЛЛАА.**1.1. Гэрээлэгч хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын хэмжээг санхүүгийн болон ӨНЗ-ын тайландаа үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна.**

1.1.1. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1² болон Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 11.2³-т заасны дагуу АМГТГ-аас холбогдох хяналт шалгалтыг хэрэгжүүлж, 2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн ӨНЗ-аас нийт дүнгээр 1,429,408.94 ам.долларын хасагдах зардал тооцсон тайлан, дүгнэлт гаргаж ирүүлсэнд аудит хийж, холбогдох анхан шатны баримт, нотлох зүйлсэд үндэслэн аудитаар нийт 1,415,154.17 ам.долларыг ӨНЗ-аас хасаж, баталгаажуулахаар шийдвэрлэлээ. Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв.

1.1.2. Аудитын хамрах хугацаанд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 6 гэрээлэгчийн 8 талбайд зарцуулсан ӨНЗ-аас аудитаар хасаж, баталгаажуулсан дүнг тоймлон гэрээлэгч бүрээр танилцуулбал:

Хүснэгт 2. Гэрээлэгчдийн хайгуулын ажлын ӨНЗ-ыг баталгаажуулсан дүн.

/ам.доллар/

Гэрээлэгч компани	Талбайн нэр	Гэрээлэг- чийн тайлагнасан ӨНЗ-ын тайлан	АМГТГ-ын тооцооллоор		Аудитаар	
			Хассан дүн	Нийт ӨНЗ	Хассан дүн	Баталгаажуул- сан нийт ӨНЗ
А	Б	1	2	3	4	5=1-4
Жи Өү Эйч ХХК	Номгон-IX	3,216,672.82	341,535.46	2,888,311.32	371,083.26	2,845,589.56
Метангаз ресурс ХХК	Тавантолгой -XXXIII	634,953.54	134,687.14	493,532.04	152,182.63	482,770.91
Тэлмэн ресурс ХХК	Гурвантэс - XXXV	173,446.77	37,630.16	133,935.10	20,282.24	153,164.53
Петровис ресурс ХХК	T-1	378,713.59	299,768.03	63,960.17	234,397.43	144,316.16
	Богд-IV	369,774.52	226,969.42	131,459.63	235,238.23	134,536.29
	Онги-V	396,440.95	228,494.46	156,524.78	236,270.47	160,170.48
Петроматад ХХК	Матад- XX	462,330.29	128,489.73	715,810.87	165,699.91	296,630.38
Монголын-Алт ⁴ ХХК	Төхөм-Х урд	480,976.08	31,834.54	447,549.81		
Дүн		6,113,308.56	1,429,408.94	5,031,083.72	1,415,154.17	4,217,178.31

Эх сурвалж: АМГТГ-ын 2023 оны 1/1541, 1/2184 дугаар албан бичиг

1.1.3. Монголын Алт (МАК) ХХК нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т заасны дагуу 2021 онд 17,309,120.00 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулах төлөвлөгөө, төсөв батлуулснаас, 888,097.77 ам.доллар буюу 5.1 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Гэвч тус компани нь 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 02/899 тоот албан бичгээр түр зогсолт авах хүсэлт хүргүүлснийг АМГТГ-ын Газрын тосны салбарын асуудал хариуцсан мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01 дугаартай хуралдааны тэмдэглэл болон Газрын тосны тухай хуулийн 8 дугаар

² Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ ... хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.

³ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, ... анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргана.

⁴ Энэ тайлангийн 1.1.3-т тусгасны дагуу ӨНЗ-ыг баталгаажуулаагүй болно.

зүйлийн 8.1.5⁵, 38 дугаар зүйлийн 38.3⁶ дахь хэсгийг үндэслэн УУХҮС-ын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/200 дугаар тушаалаар хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жилийн хугацаагаар сунгасан байна.

Иймд хайгуулын үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаагаар түр зогсоосон тул Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 3.1.30-д "хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа түр зогссон хугацаанд гарсан зардлыг ӨНЗ-д тооцохгүй" гэж заасныг үндэслэн түр зогсолт авсан хугацаанд гарсан зардлыг ӨНЗ-аас хасаж 2021 оны ӨНЗ-ыг баталгаажуулахгүй байхаар шийдвэрлэсэн.

1.1.4. Хайгуулын үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 6 гэрээлэгчийн 8 талбайд 2021 онд нийт 26,463,517.22 ам.долларын төлөвлөгөө, төсөв батлуулж, 7,574,019.98 ам.долларын гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/. Тухайн жилийн батлагдсан хөтөлбөр, төсөвт тусгасан хайгуулын ажлаас 2 гэрээлэгч 89,413.50 ам.доллараар төсөв хэтрүүлж, 1 гэрээлэгч түр зогсолт авсан ч 15,953,023.92 ам.доллараар, 3 гэрээлэгч хайгуулын ажлын доод хэмжээнээс 1,019,175.00 ам.доллараар тус тус дутуу гүйцэтгэснээр тайлагнасан байна. Үүнд:

- Петроматад ХХК-ийн Матад ХХ талбай 28,539.54 ам.доллар, Петровис ресурс ХХК-ийн Т-1 талбай, Онги-V талбай, Богд-IV талбай нийлбэр дүнгээр 60,873.96 ам.доллараар батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь ГТБТЖ-ын 3.1.3 "... холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн,..." гэж заасныг зөрчсөнд зөвлөмж өгөх;
- Монголын алт (МАК) ХХК-ийн Төхөм Х талбай нь 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 02/899 дүгээр албан бичгээр түр зогсолт авах хүсэлт гаргаж, УУХҮЯ-ны 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/200 дугаар тушаалаар Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 38 дугаар зүйлийн 38.3, АМГТГ-ын гарын тосны салбарын асуудал хариуцсан мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01 дугаартай хуралдааны тэмдэглэлийг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жилийн хугацаагаар сунгасан байна. Гэвч 17,309,120.0 ам.долларын төсөв батлуулсан, түр зогсолтын хугацаанд 480,976.08 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэж, зардал тайлагнасан нь ГТБТЖ-ын 3.1.30-д "хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа түр зогссон хугацаанд гарсан зардлыг ӨНЗ-д тооцохгүй" гэж заасныг зөрчсөн тул ӨНЗ-аас хасах;
- Харин нэр бүхий 3 гэрээлэгч 1,019,175.00 ам.доллараар төсвийг дутуу зарцуулсан нь тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөөгүй, батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу хайгуулын ажлыг бүрэн хийгээгүй байна. Энэ нь БХГ-ний 7.3.3-д "гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 хоногийн дотор Төрийн захиргааны байгууллагад төлнө" гэж заасныг зөрчсөн байна. Үүнд: Метангаз ресурс ХХК-ийн Тавантолгой-XXXIII талбай – 517,229.09 ам.доллар, Жи Өү Эйч ХХК-ийн Номгон-IX талбай – 154,410.44 ам.доллар, Тэлмэн ресурс ХХК-ийн Гурвантэс-XXXV талбай - 347,535.47 ам.доллараар тус тус дутуу зарцуулжээ.

Иймд Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл, тооцооны журам болон тус гэрээлэгчидтэй байгуулсан БХГ-ний дээрх зохицуулалтуудыг зөрчсөн тул аудитаар ӨНЗ-аас хасаж тооцлоо.

1.1.5. Гэрээлэгчид 2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлэн зарцуулсан 145,534.4 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 162,514.08 ам.доллар, зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбогдон гарсан 283,954.96 ам.доллар, тайлант хугацааны ӨНЗ-д хамраахгүй зардал 797,833.67 ам.долларын зардлыг ӨНЗ-д оруулж тайлагнасан нь Газрын тосны тухай хууль,

⁵ хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, хугацааг нь сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

⁶ Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээлэгчийн үйл ажиллагаа нэг жилээс дээш хугацаагаар саатсан бол төрийн захиргааны төв байгууллага хайгуул, ашиглалтын хугацаан дээр уг хугацааг сунган тооцно.

Газрын тосны бүртгэл, тооцооны журам болон БХГ-ний холбогдох заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- ✦ Жи Өү Эйч ХХК-ийн гэрээт Номгон IX талбайд 2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 4,413.50 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,620.28 ам.доллар, зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбогдон гарсан 283,954.96 ам.доллар, тайлант хугацааны ӨНЗ-д хамраахгүй зардал 90,979.07 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож нэмсэн захиргааны зардал 10,884.55 ам.долларын;
- ✦ Петроматад ХХК-ийн гэрээт Матад-XX талбайд 2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 131,837.64 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 20,134.03 ам.доллар, тайлант хугацааны ӨНЗ-д хамраахгүй зардал 19,353.83 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож нэмсэн захиргааны зардал 5,625.59 ам.долларын;
- ✦ Метангаз ресурс ХХК-ийн гэрээт Тавантолгой-XXXIII талбайд 2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 9,283.26 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,339.92 ам.доллар, тайлант хугацааны ӨНЗ-д хамраахгүй зардал 134,312.66 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 7,246.79 ам.долларын;
- ✦ Тэлмэн ресурс ХХК-ийн гэрээт Гурвантэс-XXXV талбайд санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 3.51 ам.доллар, тайлант хугацааны ӨНЗ-д хамраахгүй зардал 19,312.91 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 1,885.71 ам.долларын;
- ✦ Петровис ресурс ХХК-ийн гэрээт Т-1, Богд-IV, Онги V талбайд нийт 2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсөв хэтрүүлсэн 346,572.59 ам.доллар, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 138,416.34 ам.доллар, тайлант хугацааны ӨНЗ-д хамраахгүй зардал 533,875.20 ам.доллар, БХГ-д заасны дагуу тухайн жилийн хайгуулын ӨНЗ-ын хувиар тооцож хассан захиргааны зардал 33,614.59 ам.долларын зөрчлүүд илэрч байна.

Иймд аудитаар Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7⁷, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 2.2.6⁸, 3.1.3⁹, болон дээрх компаниудтай байгуулсан БХГ-ний хавсралт Г-ийн 2.4.2-д “холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй ангилалд хамаарах зардал” /Жи Өү Эйч ХХК, Тэлмэн ресурс ХХК, Петровис ресурс ХХК, Петроматад ХХК/, 3.1.2-д “нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу бүртгэсэн боловч төлөгдөөгүй зардал” /Метан газр ресурс ХХК/ гэж тус тус заасныг зөрчсөн дээрх зардлыг ӨНЗ-аас хасаж тооцлоо. Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв.

1.1.6. Мөн аудитын төлөвлөгөөнд тусгасны дагуу 2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан хэдий ч ӨНЗ-ыг нь баталгаажуулаагүй үлдсэн 3 гэрээлэгчийг аудитад хамруулан үзэхэд ӨНЗ-ыг баталгаажуулах шаардлагагүй нөхцөл үүссэн байна. Үүнд:

- ❖ Монголын алт /МАК/ ХХК-ийн Төхөм X урд талбайд Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т заасны дагуу 2020 онд 15,271,059.87 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулах төлөвлөгөө, төсөв батлуулсан хэдий ч АМГТГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/80 дугаар тушаалаар хайгуулын үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 1-ээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаагаар түр зогсоосон;
- ❖ Макс Ойл ХХК-ийн /Арбулаг - XXIX талбайд мөн 2020 онд 1,810,158.25 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулах төлөвлөгөө, төсөв батлуулсан хэдий ч АМГТГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/80 тоот тушаалаар хайгуулын үйл ажиллагааг 1 жилийн хугацаагаар зогсоосон бөгөөд тухайн хугацаанд зардал гараагүй;

⁷ Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй

⁸ Өртөг нөхөгдөх зардал нь анхан шатны баримтаар нотлогдсон байх ба анхан шатны баримт нь ажил, гүйлгээ гарсныг нотлох, бичгээр бүрдүүлсэн гэрээ болон нэхэмжлэх, төлбөрийн даалгавар, орлогын баримт, цагийн тооцоо, акт болон бусад нотлох баримтууд байна

⁹ Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн, эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй зардал

- ❖ Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайд АМГТГ-ын даргын 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн А/68 дугаар тушаалаар хайгуулын үйл ажиллагааг мөн 1 жилийн хугацаагаар түр зогсоосон.

Иймд Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 3.1.30-д "хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа түр зогссон хугацаанд гарсан зардлыг ӨНЗ-д тооцохгүй" гэж заасныг үндэслэн түр зогсолт авсан хугацаанд гарсан зардлыг ӨНЗ-аас хасаж тооцохоор шийдвэрлэлээ.

1.1.7. Хайгуулын үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй гэрээлэгчид хайгуулын зардлыг хайгуул үнэлгээний хөрөнгө, эсвэл хайгуулын зардал гэсэн 2 аргын аль нэгийг сонгож бүртгэхээр холбогдох хууль болон стандартад заасан. Гэтэл дээрх 2 аргыг давхардуулан бүртгэснээс шалтгаалан ӨНЗ-ын дүн болон орлого үр дүнгийн тайланг буруу тайлагнаж байгаа нь Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2¹⁰, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1¹¹, Сангийн сайдын 2016 оны 409 дүгээр тушаалаар батлагдсан "Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт"-ыг бүрэн нийцэхгүй байна. Тухайлбал:

- ❖ Монголын алт /МАК/ ХХК нь урьдчилж төлсөн тооцоо дансаар бүртгэдэг;
- ❖ Жи Өү Эйч ХХК нь цалин болон бусад зардлыг шууд зардлаар бүртгэж, орлого үр дүнгийн тайлангаар тайлагнадаг;
- ❖ Петроматад ХХК нь хуримтлагдсан алдагдлыг бууруулж бичилт хийдэг;
- ❖ Петровис ресурс ХХК нь санхүүгийн тайлан гаргахдаа хайгуул үнэлгээний хөрөнгийг нэмэгдүүлсэн бичилт хийж тайлагнасан байна.

Иймд гэрээлэгчдийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ дээрх хууль, стандартын заалтыг тусган, дагаж мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2. Гэрээлэгч нь БХГ болон холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2.1. Аудитын хамрах хугацаанд хайгуулын үйл ажиллагаа явуулсан дараах 4 гэрээлэгч Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулаагүй 274,945.38 ам.долларын ажил, гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэж, бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Хүснэгт 3. Гэрээлэгчдийн гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн гүйлгээний дүн.

/ам.доллар/

№	Гэрээлэгчийн нэр	Талбайн нэр	Мөнгөн дүн
1	Метангаз ресурс ХХК	Тавантолгой-ХХХIII	5,075.30
2	Жи Өү Эйч ХХК	Номгон-IX	226,653.21
3	Тэлмэн ресурс ХХК	Гурвантэс -ХХХV	18,397.87
4	Петроматад ХХК	Матад- ХХ	24,819.00
НИЙТ ДҮН			274,945.38

¹⁰ Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана

¹¹ Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6¹², 36-р зүйлийн 36.2¹³ дахь хэсэг, БХГ-ний 14.1.2¹⁴ /Номгон IX/, 15.1.2 /Тавантолгой-XXXIII, Гурвантэс - XXXV, Матад XX/-т тус тус заасныг зөрчсөн тул гэрээлэгчид хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй АМГТГ-т албан шаардлагыг хүргүүлээ.

1.2.2. Аудитад хамрагдсан гэрээлэгчид 2023 оны байдлаар Газрын тосны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2¹⁵, БХГ-ний 13.1¹⁶, 13.4¹⁷, 13.5¹⁸, 13.6¹⁹-д заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлс нийт 1,612,199.73 ам.долларыг төлөөгүй байна.

Хүснэгт 4. Хууль болон БХГ-д заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсийг 2023 оны жилийн эцсийн байдлаар төлөөгүй гэрээлэгчид

/ам.доллар/

Гэрээлэгч компани	Талбайн нэр	Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг	Сургалтын урамшуулал	Орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	Эсхрүү дансанд байршуулах	Төлөөлөгчийн болон байршуулаагүй нийт дүн
Макс ойл ХХК	Арбулаг XXIX		282,266.80	200,000.00	300,000.00		782,266.80
Метангаз ресурс ХХК	Таван-толгой-XXXIII					7,157.94	7,157.94
Петровис ресурс ХХК	T-1		15,000.00		20,000.00	5,029.00	40,029.00
	Богд-IV		15,000.00		20,000.00	7,274.00	42,274.00
	Онги-V		15,000.00		20,000.00	5,705.00	40,705.00
Петроматад ХХК	Матад- XX				18,377.67		18,377.67
Монголын - Алт ХХК	Төхөм-Х урд	68,369.32		80,000.00	40,000.00	493,020.00	681,389.32
Нийт дүн		68,369.32	327,266.80	280,000.00	418,377.67	518,185.94	1,612,199.73

Эх сурвалж: АМГТГ-ын 2023 оны 1/1541 тоот албан бичиг, холбогдох ажлын баримт

Иймд АМГТГ-т Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т "... энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

1.2.3. Гэрээлэгчид нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.10²⁰-т заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу хийх үүрэгтэй. Гэвч тайлант хугацаанд аудитад хамрагдсан гэрээлэгчдээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Монголын Алт (МАК) ХХК, Метан газ ресурс ХХК, Петровис ресурс ХХК-ууд нь байгаль орчны ажилтангүй байгаа нь БХГ-ний 9.4.4-т "гэрээлэгч нь төрийн захиргааны байгууллагад байгаль орчны нөхөн сэргээлт, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байна" гэсэн заалтыг хангаагүй;

¹² хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах

¹³ Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана

¹⁴ гэрээлэгч эсхүл оператор компани нь хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгана.

¹⁵ Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр ... төгрөг байна

¹⁶ Гэрээлэгч гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал: Гэрээлэгч нь 70,000 (далан мянга)-ын ам.долларыг гэрээт жил эхэлснээс хойш 60 (жар) хоногийн дотор улсны төсөвт шилжүүлнэ.

¹⁷ Сургалтын урамшуулал

¹⁸ Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг

¹⁹ Орон нутгийн хөгжүүлэх урамшуулал

²⁰ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу бүрэн хийж дуусгах, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах ажлын зардлыг гаргах;

- Метан газр ресурс ХХК-ийн Тавантолгой ХХХIII талбайд археологи палеонтологийн судалгаа хийлгээгүй ЭТТ ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн судалгааны дүгнэлтийг ашигласан бөгөөд энэ нь тухайн талбайг бүрэн хэмжээнд хамраагүй, үлдсэн талбайд нэмэлт дүгнэлт гаргуулаагүй нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д "... ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна" гэх заалтыг хэрэгжүүлээгүй;
- Петроматад ХХК нь 2021.06.07-ны өдөр Эко Аккюреси ХХК-тай байгаль орчны аудитын үйлчилгээг гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулж аудитын ажил хийгдсэн ч тус аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2021 онд аймгийн байгаль орчны албанд тайлагнаагүй нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-д "Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ" гэж заасныг биелүүлээгүй;
- Петроматад ХХК болон Петровис ресурс ХХК нь тайлант онд БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулаагүй БОМТ боловсруулаагүй, гүйцэтгэлийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага болох БОАЖЯ-д тайлагнаагүй нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 2.6-д "Төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа нь зах зээл, эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт үзэгдэл, тухайн бүс нутаг, хүн амыг хамарсан халдварт өвчин, тахал зэрэг давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас зогсонги байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 1 сарын дотор хандан, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулах хүсэлт гарган шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Иймд АМГТГ болон гэрээлэгч нарт Газрын тосны тухай хууль болон БХГ-д заасан үүргийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн ажлаа бүрэн гүйцэтгэж, тайлагнаж байх зөвлөмж өгч ажиллаа.

БҮЛЭГ 2. АМГТГ НЬ ГЭРЭЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ТОГТООМЖ, БХГ-НИЙ ДАГУУ ХЯНАЛТ ТАВИАГҮЙ, ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН БИЕЛҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1. АМГТГ нь холбогдох хууль тогтоомж, БХГ-д заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

2.1.1. АМГТГ-ын даргын 2022 оны А/120 дугаар тушаалаар 2020, 2021 онд уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт- ӨНЗ-ыг хянан шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг томилон ажиллуулсан байна.

Уг хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтээ Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ-аас 2023 оны 1/1541, 1/2184, 3/3192 дугаар албан бичгүүдээр ТАБ-т тус тус ирүүлсэн.

2.1.2. АМГТГ-аас ирүүлсэн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтэд аудит хийхэд дараах алдаа, зөрчил бүхий дүнтэй байна. Үүнд:

- Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын хэмжээ, санхүүгийн тайланг хянан шалгаж...” гэж заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй. Тухайлбал: Ирүүлсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтэд хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүгийн тайланг хянаж, шалгасан талаар дүгнэлт тусгаагүй;
- Гэрээлэгчдээс ӨНЗ-ын тайлан хүлээн авахдаа УУХҮС-ын 2020 оны 189 дүгээр тушаалаар батлагдсан "Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлал"-д заасан батлагдсан маягтын дагуу хүлээн аваагүй;
- ӨНЗ-ын тайланг баталгаажуулахдаа аудитлагдсан санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг ашигладаггүй, анхан шатны баримтыг үндэслэдэг гэж тайлбарлаж байгаа ч анхан шатны баримт нь тухайн тайлант хугацаанаас өмнө, эсвэл хойших хугацаанд хамарч байсан ч ӨНЗ-д оруулж тооцдог, мөн хянагдаж, дүгнэлт гаргасан ӨНЗ-ын дүн нь санхүүгийн тайлангийн аль хэсэгт тусгагдсан нь тодорхойгүй;
- Гэрээлэгчдийн хайгуулын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын холбогдох анхан шатны баримтыг бүрэн гүйцэд үзээгүйгээс зарим ӨНЗ-ын тайлангийн дүнд зөрүү үүссэн.

Иймд АМГТГ-аас гэрээлэгчийн тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт болон зардлын хэмжээг санхүүгийн тайландаа үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэх зэрэг хуульд заасан бусад мэдээллийг иж бүрэн хамруулан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, дүгнэлт тайлан гарган ТАБ-д ирүүлж байх шаардлагатай байна.

2.1.3. Мөн АМГТГ нь гэрээлэгчдээс ӨНЗ-ын тайланг хүлээн авахдаа УУХҮС-ын 2020 оны 189 дүгээр тушаалаар батлагдсан "Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлал"-д заасны дагуу тухайн оны санхүүгийн тайлан, тодруулга, ӨНЗ-ын хураангуй болон дэлгэрэнгүй тайлан, өртөг нөхөлтийн, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийн дэлгэрэнгүй тайлан, захиргааны зардлын тайлан зэргийг дутуу авч хяналтаа хийсэн байна. Үүнд:

- Жи Өү Эйч ХХК, Петроматад ХХК, Монголын Алт (МАК) ХХК-ууд нь санхүүгийн тодруулга бичээгүй, өртөг нөхөлтийн, үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй тайлан, захиргааны зардлын тайлангууд;
- Петровис ресурс ХХК нь тухайн оны санхүүгийн тайлан, тодруулга өгөөгүй, ӨНЗ-ын хураангуй болон дэлгэрэнгүй тайланг зөвхөн 3, 4 дүгээр улирлаар ирүүлсэн, өртөг нөхөлтийн, үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй, захиргааны зардлын зэрэг тайлангууд;
- Тэлмэн ресурс ХХК нь санхүүгийн тайлангийн тодруулга бичээгүй, үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй, захиргааны зардлын зэрэг тайлангуудыг тус тус хүргүүлээгүй байна.

Энэ нь БХГ-ний хавсралт "Г"-ийн 1.6-д "Гэрээлэгч эсвэл оператор компани нь хайгуулын хугацаанд дараах тайлан, мэдээг гаргаж, хуанлийн улирал дууссанаас 20 (хорь) хоногийн дотор төрийн захиргааны байгууллага болон холбогдох төрийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.1.4. Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу АМГТГ нь газрын тосны хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн "...батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, ӨНЗ-ын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг" хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа ТАБ-д ирүүлэх зохицуулалттай.

Гэтэл 2022, 2023 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн дээрх үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хянаж шалгаж, дүгнэлт гаргасан тайланг одоог хүртэл УАГ-т ирүүлээгүй байна.

Уг асуудлаар 1-2 санхүүгийн жилээр хугацаа хоцролттой байгаа зөрчлийг арилгах албан шаардлагыг өмнөх аудитаар АМГТГ-т хүргүүлсэн боловч бүрэн биелээгүй байна.

Мөн АМГТГ-аас гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ зэрэгт хяналт, шалгалт хийж, тайлан дүгнэлтийг ТАБ-д хүргүүлэх хугацааг дээр дурдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжтой уялдуулан Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, мөн Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11.6-д тодорхой тусгах зөвлөмжийг өмнөх аудитаар МУЗГ-т хүргүүлсэн боловч мөн биелээгүй байна.

Дээрх албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох журмын дагуу эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

2.1.5. АМГТГ нь хайгуулын ажлын төлөвлөгөөтэй ӨНЗ-ын тайланг уялдуулж хяналт хэрэгжүүлдэггүйгээс гэрээлэгчид хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэсэн эсэхэд хяналт шалгалт хийгдээгүй байна. Үүнд:

- Метангаз ресурс ХХК-ийн Тавантолгой-XXXIII талбай - 517,229.09 ам.доллар, Жи Өү Эйч ХХК-ийн Номгон-IX талбай - 154,410.44 ам.доллар, Тэлмэн ресурс ХХК-ийн Гурвантэс-XXXV талбай - 347,535.47 ам.доллараар буюу нийт 1,019,175.00 ам.доллараар төсвийг дутуу зарцуулжээ.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.12-т "Хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгэх үүргээ хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй", БХГ-ний 7.3.3-д "гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 хоногийн дотор Төрийн захиргааны байгууллагад төлнө" гэсэн заалт хэрэгжихгүй байгаа тул АМГТГ-т төлбөрийн акт тогтоолоо.

2.1.6. Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд холбогдох байгууллагатай хамтран шалгалт хийхээр заасан боловч УУХҮЯ-аас тодруулахад хяналт шалгалтын ажил хийгдээгүй бөгөөд ирэх онд

хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа талаар албан тоот²¹ ирүүлсэн тул тус аудитаар албан шаардлага хүргүүлээ.

2.2. Өмнөх аудит буюу 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн ӨНЗ-ыг баталгаажуулах аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.2.1. Өмнөх аудит буюу 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн ӨНЗ-ыг баталгаажуулах аудитаар МУЕС-д 1, УУХҮС-д 3, АМГТГ-ын даргад 10, хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч нарт 4 зөвлөмж буюу нийт 18 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж нь 50 хувийн хэрэгжилттэй, бусад нь хэрэгжээгүй байна. Үүнд:

Хүснэгт 5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

№	Хариуцах албан тушаалтан	Өгөгдсөн зөвлөмжийн утга	Тайлбар
1	МУЕС-д	Төрийн холбогдох байгууллагаас гэрээлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгож, Засгийн газрын 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журам болон 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмыг уялдуулан өөрчлөлт оруулах.	Өөрчлөлт оруулаагүй.
2	УУХҮС-д	Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлээгүй.
3		МУЗГ-т хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага журам болон 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмыг уялдуулан боловсруулж, батлуулах арга хэмжээ авах.	Журмуудыг уялдуулан хангаагүй.
4		ТЕЗ-аас АМГТГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжид заасан төлбөр урамшууллын төвлөрүүлэлт, гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах.	Дотоод хяналт сайжраагүй, хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэн.
5	АМГТГ-т	Гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг батлахдаа цаг үеийн нөхцөл байдлыг бодитоор үнэлэн, тооцоо судалгаагаар шийдвэр гаргах.	Төсөв батлахдаа судалгаагүй шийдвэр гаргасан хэвээр байна.
6		Гэрээлэгчдийн хайгуулын үйл ажиллагаа, хууль тогтоомжид заасан төлбөр урамшууллын төлөлт болон хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавих ажлаа үр дүнтэй хэрэгжүүлэх.	Төлбөр урамшуулал тогтоосон хугацаанд төлөгддөггүй, хугацаа хоцроож төлдөг, зарим гэрээлэгч төлөөгүй.

²¹ УУХҮЯ-аас ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03/2731 тоот албан бичиг

7		Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК-тай байгуулсан БХГ-ний 7.3.3 дахь заалтыг МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл тооцооны журмын 3.1.37-т нийцүүлж, эрх зүйн зөрчлийг арилгах.	Эрх зүйн зөрчлийг арилгаагүй.
8		ГТГ-ын даргын 2013 оны 28 дугаар тушаалаар баталсан Газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд мөрдөх жишиг үнийг зах зээлийн ханштай уялдуулж шинэчлэх.	Жишиг үнэ шинэчлээгүй.
9		Монголын алт /МАК/, Макс Ойл, Петроматад ХХК-уудын 2020 онд зарцуулсан зардлын гүйлгээг "он дамнасан зардал" гэсэн нэршлээр 2019 оны ӨНЗ-д оруулж тооцсон тайлан, дүгнэлтэд залруулга хийж ирүүлэх.	Он дамжуулан хийсэн гүйлгээ гэж тайлагнасан боловч түр зогсолтын хугацаанд гүйлгээ гаргаснаар ӨНЗ-д тайлагнасан.
10		Гэрээлэгчдийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, чиглэл өгч байгаа өдөр тутмын ажлын тайлан, баримт материалдаа үндэслэн Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан хяналт шалгалтыг тухай бүр уядуулан хэрэгжүүлж, тайлан гаргадаг байхаар ажлын зохион байгуулалтыг сайжруулах.	Өдөр тутмын ажлын байрны хяналт тавьдаггүйгээс УУХҮС-ийн 189 дүгээр тушаалаар батлагдсан маягтуудын дагуу мэдээ, тайлан бүрэн авдаггүй.
11		Гэрээлэгчдийн ӨНЗ-ын тайлан болон хяналт шалгалтын тайлангийн жишиг загварыг бий болгож, тайланг хүлээн авах, хүргүүлэх зэрэг асуудлыг журамлах.	Тайлангийн жишиг загвар бий болгоогүй.
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrpam.gov.mn,
Цахим хуудас: mrpam.gov.mn

2023.12.11 № 1/5827
танай 2023.12.01-ны № 06/2466 -т


Санал, тайлбар хүргүүлэх
тухай

Танай газраас 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06/2466 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит"-ын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасны дагуу аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРМАНДАЛ



Аудитын тайлангийн төсөл дэх дүгнэлтэд өгөх тайлбар, санал

Дүгнэлтийн 1-д:

АМГТГ нь 2021 оны өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтыг хийж, нийт 1,429,408.94 ам.долларын зардлыг хассан дүгнэлтийн төслийг 2023 оны 3 дугаар сарын 3/1306, 3/1307, 3/1308, 3/1341, 3/1342, 04 дүгээр сарын 3/1775 дугаартай албан бичгүүдээр 6 гэрээлэгчид хүргүүлсэн.

Аудитын тайлангийн төсөлд ӨНЗ-аас хассан 1,415,154.17 ам.долларын зардлын тайлбар саналыг гэрээлэгчдээс тодруулна уу.

Дүгнэлтийн 2-т:

Хяналт шалгалтаар үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулалгүй ажил гүйлгээг хийж, бүртгэлд тусгаж тайлагнасан Метан газ ресурс ХХК, Жи Өү Эйч ХХК, Петроматад ХХК, Тэлмэн ресурс ХХК-ийн нийт 257,775.68 ам.долларын гүйлгээг өртөг нөхөгдөх зардлаас хасаж, дүгнэлтийн төслийг гэрээлэгч нарт хүргүүлж ажилласан.

Петроматад ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3/1553, Капкорп Монголиа ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3/1555, Жи Өү Эйч ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3/1554 дугаар албан бичгээр хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар мэдэгдсэн.

Өртөг нөхөгдөх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан, үйл ажиллагаанд хамаарах гэрээ, тооцооны хуудас зэрэг санхүүгийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийг гадаад хэлээр үйлдэж, хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэрээлэгчдийн асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 3/1733 тоот албан бичгээр хүргүүлсэн. УУХҮЯ-аас манай газарт 2023 оны 5 дугаар сарын 11/1110 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн бөгөөд "хариуцлага тооцох" чиг үүргийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 29-ний 1/2694 албан бичгийг Сангийн яаманд хандсан бөгөөд одоогоор хариу ирүүлээгүй байна.

Гэрээлэгчдийн зүгээс санхүүгийн баримт бүрийг орчуулах нь компанийн зардал өртгийг нэмэгдүүлнэ гэсэн тайлбарыг тавьдаг хэдий ч АМГТГ нь санхүүгийн анхан шатны баримтыг Монгол хэлээр үйлдэх шаардлагыг байнга тавьдаг.

Дүгнэлтийн 3-т:

АМГТГ нь Газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг ханган Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д "...энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Гэрээлэгчдэд "Төлбөр төлөх тухай" 2023 оны 01 дүгээр сарын 2/515, 2/516, 2/517, 2/518, 2/564, 2/565, 2/572, 2/686 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

АМГТГ-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/1541 дугаартай албан бичгээр 2021 оны байдлаар тусгай зөвшөөрлийн төлбөр Метан газ ресурс ХХК 398.58 ам.долларын илүү төлөлт, сургалтын урамшуулалт Жи Өү Эйч ХХК 2632.28 ам.долларын илүү төлөлт, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг Петровис ресурс ХХК 45,000.00 ам.долларын дутуу төлөлттэйгөөр тайлагнасан дүгнэлтийг УАГ-т хүргүүлсэн.

Газрын тосны тухай хуулийн 10.1-т "энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн байгуулсан сум, дүүргийн Засаг дарга болон тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих", 11.2.17-д "ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгаасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах", 34.4-д "Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх сайн шилжүүлэх" гэж заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нар гэрээний хэрэгжилтэд хяналт тавин, ажиллах үүрэгтэй учраас АМГТГ нь орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлэх, төвлөрүүлэх мөнгийг хянах боломжгүй.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д "...тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь...", 4 дүгээр зүйлийн 4.1.27-д "хайгуулын ажлын зардал" гэж энэ хуулийн 4.1.8-д заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг" гэж заасны дагуу гэрээлэгчдийн эсхрөө дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг, Газрын тосны бүртгэл тооцооны журмын 8.5-т "Энэ журмын 8.3-т заасан төсвийн дагуу тооцож, эсхрөө дансанд байршуулсан баталгаа нь тухайн жилийн гүйцэтгэлээр баталгааны дүнгээс дутуу бол нэмж байршуулах, илүү бол дараа жил байршуулах баталгаанд шилжүүлэн тооцоо" гэж заасны дагуу УАГ-ын Баталгаажсан хайгуулын ажлын хөрөнгө оруулалтаас тооцно. Иймд УАГ-ын Баталгаажсан хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын тайлан гарсны дараа тооцоо.

УАГ-ын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №01/А0150046АХГ-2022/10-НА-СТА дугаар бүхий төлбөрийн актад тусгагдсан 2022 оны үлдэгдэл төлбөр Капкорн Монголиа ХХК 75,000.0 ам.долларыг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр, Монголын алт ХХК-ийн 113,079.70 ам.долларын төлбөрийг 2023 оны 01 дүгээр сарын 25, 02 дугаар сарын 01-ны өдөр "Төлбөрийн акт" ирэхээс өмнө төлсөн.

Шунхлай энерги ХХК, Макс ойл ХХК-уудын өмнөх онуудын хуримтлагдсан төлбөр, урамшууллын үлдэгдлийн асуудал арбитрын болон шүүхийн маргаантай байна.

Дүгнэлтийн 4-д:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3.6 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөвтэй уялдуулах, хайгуулын ажлын төлөвлөгөө төсөв болон менежментийн төлөвлөгөөний уялдааг хангах чиглэлээр хэрхэн хамтран ажиллах талаар Байгаль орчин аялал жуулчлалын яаманд 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 1/2500 тоот албан бичгээр хандсан болно. Өнөөдрийг хүртэл БОАЖЯ-аас хариуг ирүүлээгүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулах шаардлагатай бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг

Дүгнэлтийн 8-д:

Гэрээлэгчдээс ирүүлсэн ӨНЗ-ын тайланг батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн эсхийг анхан шатны баримтад үндэслэн Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл тооцооны журам, бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний хүрээнд ажлын хэсэг хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Гэрээлэгчид хайгуулын үйл ажиллагаатай холбоотой нийт зарцуулсан "өртөг нөхөх болон нөхөхөдөгүү зардал"-ыг хайгуул, үнэлгээний хөрөнгө" дансанд тайлагнадаг.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүрэгийг хэрэгжүүлнэ", 17.1.7-т "...Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрөөд үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгааг харилцааг санхүүгийн байгууллагаатай хамтран хяналт тавих", Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх,нэгтгэлийн мэдээллийг ашиглаж журам"-ын 3.3-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаатай харьцдаг дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайланг цахим хэлбэрээр болон батлаасан маягийн дагуу бичлэнг туслаах ба Сангийн яамны тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газраар хянуулсны үндсэн дээр хүлээн авна", 3.3.2-т "Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан" гэж заасны дагуу хянаж, хүлээн авсан, баталгаажсан санхүүгийн тайланг АМГТГ-т ирүүлдэг.

Санхүүгийн тайлангийн хүлээн авах, хянах чиг үүргийнхээ дагуу Сангийн яам хянадаг тул АМГТГ нь "Хайгуул үнэлгээний хөрөнгө" дансанд ӨНЗ-ыг тайлагнасан эсэхэд хяналт тавьж ажилладаг.

Дүгнэлтийн 9-д:

Аудитаар АМГТГ-т 4,086,134.82 ам.долларын төлбөрийн актын талаар:

1. АМГТГ-аас БХГ-ний 7.3.1-т заасны дагуу хавсралт В-д заасан хайгуулын ажлын доод хэмжээгээс багагүйгээр тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг баталдаг бөгөөд хайгуулын ажлын БОМТ-ыг хянаж батлах, орон нутаг иргэдийн эсэргүүцлийн улмаас ажил саатах, зогсох байдал үүсдэг. Үүнээс шалтгаалан хайгуулын ажлын доод хэмжээнд хүрэхгүй байх нөхцөл бүрддэг бөгөөд үүнийг гэрээлэгчээс шалтгаалсан гэж үзэх боломжгүй байдаг.

- Метангаз ресурс ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-д "Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн наришчлалын үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ" гэж заасны дагуу 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр БОННУ-ний тайланг батлуулж, хайгуулын ажлаа эхэлсэн. Мөн Монгол Улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас 2021 оны 12 дугаар 20-ний өдрийн 02/662 дугаар "Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ"-г олгогдсон байсан.

- Тэлмэн ресурс ХХК нь "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4-д "Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт

боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага буюу БОАЖЯ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж баталдаг.

Дүгнэлтийн 5-т:

Коронавирус-цар тахлын улмаас өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтад үүссэн хохирогдлыг арилгахаар төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ба уг төлөвлөгөөг өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтын явцын мэдээлэл, биелэлтийн хамт АМГТГ-ын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 1/1542, 06 дугаар сарын 20-ны өдрийн 1/3153 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг хийж, дүгнэлтийг 2023 оны 12 сард багтаан УАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. Хийгдэж байгаа ажлууд:

- Хайгуулын гэрээлэгчдийн 2022 оны өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтыг хийж, дүгнэлтийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 3/5579, 3/5580, 3/5581, 3/5582, 3/5583 дугаар албан бичгүүдээр санал авахаар 5 гэрээлэгчдэд хүргүүлсэн.
- Доншён газрын тос (Монгол) ХХК 2019-2021 оны хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.

Дүгнэлтийн 6-д:

АМГТГ нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11 дүгээр хэсэгт үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардалд хяналт шалгалт гүйцэтгэж байна. Одоогийн мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой заагаагүй бөгөөд Газрын тосны бүртгэл тооцооны журамд өөрчлөлт оруулах замаар хугацааг тодорхой болгох шаардлага гарч байна.

Газрын тосны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Гэрээлэгч хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө" гэж заасны дагуу тайланг хүлээн авснаас хойш гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажилд хяналт шалгалтыг эхлүүлнэ.

Дүгнэлтийн 7-д:

АМГТГ нь Газрын тосны тухай хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан чиг үүргийн дагуу газрын тостой холбогдох үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажилладаг. Гэрээлэгчдэд зориулсан манай газраас албан ёсны цахим хаяг нээж өгсөн бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллээ тогтмол ирүүлдэг /гэрээлэгч@mptr.gov.mn/. Эдгээр ирүүлсэн мэдээллүүдэд чиглэл чиглэлийн дагуу хариуцсан мэргэжилтнүүд нь хяналт тавин удирдлагыг мэдээлэлээр ханган ажилладаг. Тухайн хариуцсан мэргэжилтэн бүр өөрийн чиглэлийн мэдээллийг боловсруулан фонд үүсгэн цахим хэлбэрээр хадгалдаг. Хайгуулын үйл ажиллагаагаа дууссаны дараа ирүүлсэн тайлангуудыг тухайн жилийн төлөвлөгөө, төсөв, өдөр тутмын мэдээ зэрэгтэй харьцуулан хяналт тавьдаг. Гэрээлэгч тайланд өдөр тутмын цахимаар ирүүлсэн мэдээ, өрмийн ажил эхлэх болон дуусах мэдэгдэл зэрэг чухал баримтуудыг тайланд хавсралт болгон ирүүлдэг. Тайлан мэдэхгүй хүлээн авах, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах үүднээс газрын тосны талбайн нэгдсэн мэдээллийн цахим систем-программтай болох асуудлыг хэлэлцэж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

бичиг болно" гэж заасны дагуу 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан тул хайгуулын ажлаа эхлүүлсэн. Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө төсвийг биелүүлэх боломжгүй нөхцөл байдлаар үүссэн талаар 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр АМГТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст мэдэгдэж, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 9/5350 тоот албан бичгээр хариуг хүргүүлж байсан.

- Жи Өү Эйч ХХК нь 2021 оны ирүүлсэн өртөг нөхөгдөх зардлын тайланд 3,098,880.85 ам.долларын дүнгээрээ тайлагнаж ирүүлсэн нь хайгуулын ажлын доод хэмжээнд хүрч байна.

Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК-ууд нь тухайн онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын ажлыг гүйцэтгэх цаг хугацааны хувьд ямар ч боломжгүй болсон. Иймд Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК, Жи Өү Эйч ХХК-иудын нийт 2,393,935.09 ам.долларын төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

2. Газрын тосны тухай хууль болон БХГ-д заасан төлбөр урамшуулал, үйлчилгээний хөлсийг АМГТГ-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/1541 дугаартай албан бичгээр УАГ-т хүргүүлсэн. Үүнд: 2021 оны жилийн эцсийн байдлаар:

- Тусгай зөвшөөрлийн төлбөр Метан газ ресурс ХХК 398.58 ам.долларын илүү төлөлттэй, Монголын алт (МАК) ХХК өр төлбөргүй байсан.
- Сургалтын урамшуулал Жи Өү Эйч ХХК 2,632.28 ам.долларын илүү төлөлттэй
- Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг Петровис ресурс ХХК 45,000.00 ам.долларын дутуу ба өр төлбөртэй тайлагнасан байсан.

Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т "энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн байгуулсан сум, дүүргийн Засаг дарга болон тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгаасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих", 11.2.17-д "ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгаасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах", 34.4-д "Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлнэ" гэж заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нар гэрээний хэрэгжилтэд хяналт тавин, ажиллах үүрэгтэй. Гэрээ байгуулсан сум, дүүргийн Засаг дарга нар орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх, хяналт тавин, ажиллах тул 418,377.67 ам.долларын төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д "...тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь...", 4 дүгээр зүйлийн 4.1.27-д "хайгуулын ажлын зардал" гэж энэ хуулийн 4.1.8-т заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг" гэж заасны дагуу гэрээлэгчдийн эсхрөө дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг байршуулсан. Газрын тосны бүртгэл тооцооны журмын 8.5-т "Энэ журмын 8.3-т заасан төсвийн дагуу тооцож, эсхрөө дансанд байршуулсан баталгаа нь тухайн жилийн гүйцэтгэлээр баталгааны дүнгээс дутуу бол нэмж байршуулах, илүү бол дараа жил байршуулах баталгаанд шилжүүлэн тооцоо" гэж заасны дагуу УАГ-ын Баталгаажсан хайгуулын ажлын хөрөнгө оруулалтаас тооцох тул хяналт, шалгалтын дүнгээс тооцсон 518,185.94 ам.долларыг төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

Макс ойл ХХК нь өмнөх онуудын хуримтлагдсан төлбөр, урамшууллын үлдэгдэлийн асуудал арбитрын олон шүүхийн маргаантай байна.

Зөрчил арилгуулах талаар:

Петроматад ХХК-ийн 2020 он, Монголын алт /МАК/ ХХК-ийн 2020, 2021 онд гаргасан зардал нь 2019 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын төлбөрийн төлөлт бөгөөд ковид цар тахлын улмаас эдгээр гэрээлэгчдийн 2020, 2021 оны хайгуулын хугацааг түр зогсоосон.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг", Газрын тосны бүртгэл тооцооны журмын 11.2-т "Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны нь байгууллага нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, хуваарилалтын тайланг анхан шатны баримт материалд үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргана" гэж заасны дагуу дээр дурдсан гэрээлэгчдийн 2019 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийгдсэн хайгуулын ажлын төлбөрийг 2020, 2021 онд төлсөн баримтад үндэслэн ӨНЗ-д, тус журмын 3.1.30-д "хайгуулын үйл ажиллагаа түр зогссон хугацаанд гарсан зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй" гэж заасны дагуу 2020, 2021 онд зарцуулсан үйл ажиллагааны зардлыг ӨНЗ-аас хасаж тооцсон болно.

АМГТГ-ын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох талаар:

2022, 2023 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн ӨНЗ-ыг Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хянаж шалгаж, дүгнэлт гаргасан тайланг одоог хүртэл УАГ-т ирүүлээгүй, өмнөх аудитын албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох журмын дагуу эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр тусгагдсан байна.

Үндэсний аудитын газрын өртөг нөхөх зардлыг баталгаажуулах Хайгуулын 2019-2020 оны аудитын албан шаардлагын дагуу:

- Петроматад ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3/1553, Капкорп Монголиа ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3/1555, Жи Эйч ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 3/1554 дугаар албан бичгээр хууль, гэрээгээр хүлээн зүргээ биелүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар мэдэгдсэн.
- Өртөг нөхөгдөх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан, үйл ажиллагаанд хамаарах гэрээ, тооцооны хуудас зэрэг санхүүгийн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийг гадаад хэлээр үйлдэж, хууль, гэрээгээр хүлээн зүргээ зөрчсөн гэрээлэгчдийн асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 3/1733 тоот албан бичгээр хандсан. УУХУЯ-аас манай газарт 2023 оны 5 дугаар сарын 11/1110 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн бөгөөд албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 29-ний 1/2694 албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3.6 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөвтэй уялдуулах, хайгуулын ажлын төлөвлөгөө

Зөвлөмжийн 1-д:

ГТГ-ын даргын 2013 оны 28 дугаар тушаалаар баталсан Газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд мөрдөх жишиг үнийг зах зээлийн ханштай уялдуулж шинэчлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд гэрээлэгч компаниуд болон мэргэжлийн холбоодоос санал авахаар 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 3/1815 дугаар албан бичгийг хүргүүлсэн бөгөөд Петроматад ХХК-аас холбогдох асуудлаар санал ирүүлсэн болно. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд мөрдөх жишиг үнийг зах зээлийн ханштай уялдуулж шинэчлэх ажил судлагдах шатанд байна.

Зөвлөмжийн 2-т:

БОАЖСайдын 2019 оны А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 2.6-д "Төсөл хэрэгжүүлэхийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа нь зах зээл, эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт үзэгдэл, тухайн бус нутаг, хүн амьсг хамаарсан халдварт өвчин, тахал зэрэг дэвсгэвэлгүй хүчин зүйл үүсгэнэсний улмаас зогссон байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад дэвсгэвэлгүй хүчин зүйл үүсгэнэс хойш 1 сарын дотор хандан, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулах хууцалт гарган шийдвэрлүүлнэ" гэж заасны дагуу Гэрээлэгч нь ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

Зөвлөмжийн 3-т:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 17.1.7-д "...Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү стандартыг хэрхэн мөрдөж байгааг харилцагч санхүүгийн байгууллагатай хамтран хяналт төвх", Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам"-ын 3.3-т "Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харьцдаг дараах аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайланг цахим хэлбэрээр болон батлагдсан маягтын дагуу биечлэн тушаах ба Сангийн яамны тухайн чиглэлийн асуудлыг хариуцаж буй газраар хянуулсны үндсэн дээр хүлээн авна", 3.3.2-т "Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан" гэж заасны дагуу хянаж, хүлээн авсан, баталгаажсан санхүүгийн тайланг манай газарт ирүүлдэг. Санхүүгийн тайлангийн хүлээн авах, хянах чиг үүргийнхээ дагуу Сангийн яам хянадаг тул манай газар "Хайгуул үнэлгээний хөрөнгө" дансанд ӨНЗ-ыг тайлагнасан эсэхэд хяналт тавьж ажилласан.

Зөвлөмжийн 4-д:

Газрын тосны тухай хууль, БХГ-нд заасан үүргийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн ажилд байнгын хяналт тавьж ажилладаг.

Зөвлөмжийн 5-т:

Гэрээлэгчдээс ӨНЗ-ын тайланг УУХУСайдын 2020 оны 189 дүгээр тушаалаар батлагдсан "Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлал"-ын дагуу тухайн оны санхүүгийн тайлан, ӨНЗ-ын хураангуй болон дэлгэрэнгүй тайлан, өртөг нөхөлтийн, үндсэн хөрөнгө, бараа материалын орлого,

төсөв болон менежментийн төлөвлөгөөний уялдааг хангах чиглэлээр хэрхэн хамтран ажиллах талаар Байгаль орчин аялал жуулчлалын яаманд 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 1/2500 тоот албан бичгээр хандсан боловч хариуг ирүүлээгүй байна.

- Зөвлөмжийн дагуу заруулга хийж Монголын алт /МАК/ ХХК, Петроматад ХХК, Макс ойл ХХК-ийн өртөг нөхөгдөх зардлын шалгалтын дүгнэлт, тайланг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 3/3192 дугаартай албан бичгийг Үндэсний Аудитын газарт хүргүүлсэн.
- АМГТГ-ын даргын тушаалаар албан үүргээ гүйцэтгээгүй албан тушаалтанд хариуцлага тооцон, сахилгын шийтгэл ногдуулсан.
- Коронавирус-цар тахлын улмаас өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтад үүссэн хоцрогдлыг арилгахаар төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ба уг төлөвлөгөөг өртөг нөхөгдөх зардлын хяналт, шалгалтын явцын мэдээлэл, биелэлтийн хамт АМГТГ-ын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 1/1542, 06 дугаар сарын 20-ны өдрийн 1/3153 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

2022, 2023 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн хяналт шалгалтын талаар:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 06 дугаар 28-ны өдрийн А/117 дугаар тушаалаар "Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчдийн 2022 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримтад үндэслэн Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл тооцооны журам, бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний хүрээнд хяналт, шалгалтыг хийх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчдийн 2022 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримтад үндэслэн хяналт, шалгалтыг хийж дуусган, "Газрын тосны бүртгэл, тооцооны журам"-ын 11.4 дэх хэсэгт заасны дагуу хяналт, шалгалтын дүгнэлтийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 3/5579, 3/5580, 3/5581, 3/5582, 3/5583 дугаар албан бичгүүдээр санал авахаар 5 гэрээлэгчдэд хүргүүлсэн.
- Шалгалтын дүгнэлтийг гэрээлэгч компанийн саналын хамт 2023 оны 12 дугаар сард багтаан Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.
- 2023 онд гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын ӨНЗ-ын хяналт шалгалтыг Газрын тосны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Гэрээлэгч хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө" гэж заасны дагуу тайланг хүлээн авснаас хойш буюу 2024 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлнэ.

Иймд АМГТГ нь өмнөх аудитын хайгуулын гэрээлэгчдийн 1-2 жилийн хугацаа хоцрогдолтой байгаа зөрчлийг арилгаж, албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

зарлага, үлдэгдлийн дэлгэрэнгүй тайланг хүлээн авдаг. Гэрээлэгчийн захиргааны зардлын хувь хэмжээг БХГ-ний хавсралт "Г"-ийн 2.1.16-д "тухайн жилийн өртөг нөхөх зардлын дүнгээс дараах хувь хэмжээгээр тооцсон захиргааны зардал" -ыг ӨНЗ-д тооцох тул хяналт, шалгалтаар ӨНЗ-д тооцох дүнгээс гэрээнд заасан хувиар захиргааны зардлыг тооцдог.

Зөвлөмжийн 6-д:

Газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг ханган Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9. "...энэ хуулийн 30, 31, 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Цаашид дотоод хяналтыг сайжруулж ажиллана.

Зөвлөмжийн 7-д:

Сангийн сайдын 2016 оны 409 тоот тушаалаар батлагдсан "Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт"-ын 4.2.2.4.2-т "Аж ахуйн нэгж ямар зардлуудыг хайгуул үнэлээний хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх тухай нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тодорхойлох ба уг бодлогоо цаашид тууштай мөрдөнө" гэж заасны дагуу гэрээлэгч нарт сургалт зохион байгуулахад хамтран ажиллана уу.

Иймд дээрх тайлбар үндэслэл, саналыг аудитын дүгнэлт, зөвлөмж, шаардлагад тусгаж өгөхийг хүсье.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АМГТГ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Санал	ҮАГ-ын тайлбар
Дүгнэлт 1-д	Төрийн аудитын тухай хуулийн 19 болон 22 дугаар зүйлд заасны дагуу аудитад хамрагдсан гэрээлэгч нарт мэдэгдсэн.
Дүгнэлт 2-т	Тайлангийн 1.2.1-д тусгасны дагуу гэрээлэгчид хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй АМГТГ-т албан шаардлагыг хүргүүлэхээр болсон.
Дүгнэлт 3-т	Тайлангийн 1.2.2-д тусгасны дагуу төлбөр барагдуулах тухай төлбөрийн актыг АМГТГ-т хүргүүлэхээр болсон.
Дүгнэлт 4-т	Дүгнэлтийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Дүгнэлт 5-д	Тайлангийн 2.1.4-т тусгасны дагуу өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй эрх бүхийн албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр болсон.
Дүгнэлт 6-д	Тайлангийн 2.1.4-т тусгасны дагуу өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй эрх бүхийн албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага АМГТГ-т хүргүүлэхээр болсон.
Дүгнэлт 7-д	Дүгнэлтийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Дүгнэлт 8-д	Тайлангийн 1.1.7-д тусгасны дагуу албан шаардлагыг хүргүүлж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
Дүгнэлт 9-д	Тайлангийн 1.1.4 болон 2.1.5-д тусгасны дагуу гэрээлэгч бүрээс саналыг авч төлбөрийн актын дүнд өөрчлөлт оруулсан. Мөн аудитын ажлын баримтаар нотлогдож байгаа тул бусад саналыг хүлээн авах боломжгүй.
Зөрчил арилгуулах талаар	Тайлангийн 1.1.2-т дэлгэрэнгүй тайлбарласан тул саналыг хүлээн авах боломжгүй.
Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох талаар:	Дүгнэлтийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 1-д	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 2-т	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 3-т	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 4-т	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 5-д	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 6-д	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.
Зөвлөмж 7-д	Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч тайлбар ирүүлсэн тул нэмж тайлбар оруулаагүй.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 12 дугаар сарын 15 № 256/А0150046

Улаанбаатар хот

СНАГ-2023/10-НА-НА

Төлбөрийн акт барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөх болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар нь дараах гэрээлэгчдээс тухайн жилийн хайгуулын ажлын доод хэмжээг дутуу гүйцэтгэсний нийт 1,019,175.0 ам.долларын зарцуулагдаагүй хөрөнгийг гэрээнд заасны дагуу төлүүлээгүй байна.

- Метангаз ресурс ХХК-ийн Тавантолгой ХХХИ талбайн 517,230.0 ам. доллар,
- Жи Өү Эйч ХХК-ийн Номгон-IX талбайн 154,410.0 ам.доллар,
- Тэлмэн ресурс ХХК-ийн Гурвантэс ХХХV талбайн 347,535.0 ам.доллар.

Энэ нь БХГ-ний 7.3.3 -д "гэрээлэгч нь тухайн жилд гүйцэтгэх хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй тохиолдолд Газрын тосны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээхээс гадна гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш 30 хоногийн дотор Төрийн захиргааны байгууллагад төлнө" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5.-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дээрх нэр бүхий гэрээлэгчдээс нийт 1,019,175.00 (нэг сая арван есөн мянга нэг зуун далан таван) ам.долларыг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Баярмандал/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Л.
АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ
Д.ОТГОНБАЯР

0001093427



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 12 дугаар сарын 15 № 257/A0150046

Улаанбаатар хот

СНАГ-2023/10-НА-НА

Төлбөрийн акт барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөх болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар нь дараах гэрээлэгчдээс 2020 онд нийт 973,890.0 ам.долларын тусгай зөвшөөрөл, төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэгийг төлүүлээгүй байна.

- Макс ойл ХХК-ийн Арбулаг ХХИХ талбай 782,267.0 ам.доллар
- Монголын алт ХХК-ийн Төхөм-Х урд талбай 188,369.0 ам.доллар,
- Петроматад ХХК-ийн Матад ХХ талбай 3,254.0 ам.доллар.

2021 онд нийт 638,309.0 ам. долларын байгаль орчны баталгаа, төлбөр, урамшуулал, үйлчилгээний дэмжлэгийг төлүүлээгүй байна.

- Монголын алт ХХК-ийн Төхөм Х урд талбайн 493,020.0 ам.доллар,
- Петровис ресурс ХХК-ийн Богд IV, Онги V, Т-I талбайнууд 123,008.0 ам. доллар,
- Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 15,123.0 ам.доллар,
- Метан газ ресурс ХХК-ийн Тавантолгой ХХХIII талбайн 7,158.0 ам.доллар

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д "...энэ хуулийн 30, 34 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрөл, төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй; гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

0001090429

1. Дээрх нэр бүхий гэрээлэгчдээс нийт 1,612,199.0 (нэг сая зургаан зуун арван хоёр мянга нэг зуун ерэн есөн) ам.долларыг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Баярмандал/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Я.САМБУУНЯМ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 12 дугаар сарын 15 № 1137/A0150046

Улаанбаатар хот

СНАГ-2023/10-НА-НА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөх болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар Ашигт малтмал, газрын тосны газар хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Үндэсний аудитын газраас 2019-2020 оны хайгуулын ӨНЗ-ын баталгаажуулалт хийсэн өмнөх аудитаар илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 9 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
2. АМГТГ-аас гэрээлэгчээс ирүүлсэн тайланг хянаж шалгасан дүгнэлт, тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр хуульд заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 2022 оны өртөг нөхөгдөх зардлын тайланд баталгаажуулалт хийгдээгүй, хугацаа хоцрогдолтой байна.
3. Гэрээлэгчээс ирүүлсэн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланд тусгасан эсэхийг хянаж хүлээж аваагүй.
4. Гэрээлэгчид өртөг нөхөгдөх зардлын гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн байхад Ашигт малтмал, газрын тосны газар нь БХГ-ний дагуу хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээлэгчдэд хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1¹ д" Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6, МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын тосны бүртгэл тооцооны журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1² заалтуудыг тус тус бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ ... болон санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.


² Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3, 9.1.8, 9.1.10, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, зарцуулсан зардал, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, төлбөр Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах
2. Гэрээлэгчид тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Баярмандал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



Я.САМБУУНЯМ
Д.ОТГОНБАЯР